



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/05

Өлгий

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн аварга малчин шалгаруулах журам"-ыг 1 дүгээр, "Аймгийн аварга саальчин шалгаруулах журам"-ыг 2 дугаар, "Аймгийн аварга тариаланч хамт олон, Аймгийн аварга тариаланч шалгаруулах журам"-ыг 3 дугаар, "Аймгийн аварга анчин шалгаруулах журам"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай

2. Аймгийн хошой аварга малчин, Аймгийн аварга малчин, Аймгийн аварга саальчин, Аймгийн аварга тариаланч хамт олон, Аймгийн аварга тариаланч, Аймгийн аварга анчдыг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Ербол/-т даалгасугай.

3. Энэ журмыг 2018 оны 1 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдөж, мөн өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын "Болзол, журам батлах тухай" 2013 оны 693 дугаар захирамжийн 2,3,4,5,6 дугаар хавсралтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА А. ГЫЛЫМХАН

